



**ЕСӨНЗҮЙЛ СУМАНД ХЭРЭГГИЖ БУЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙН МЭДЭЭ**

2024.10.08

Мөнхбулаг

| № | Холбогдох эрхзүйн акт | | | | | Хэрэгжилтийн явц /хувь/ |
|--|-----------------------|--------|----------------------------|--------|---------|-------------------------|
| | Он, сар, өдөр | Дугаар | Хяналтанд авсан заалтын | | Хугацаа | |
| | | | Д/д | Дугаар | | |
| Нэг. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралын тогтоол | | | | | | |
| 1 | 2013.03.14 | 21 | 1 | 2 | | Хэрэгжих шатандаа 70% |
| 2 | 2015.07.03 | 53 | 2 | 3 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 3 | 2016.10.24 | 61 | 3 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 4 | 2018.06.27 | 08/02 | 4 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 5 | 2018 | 36 | 5 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 6 | 2018.11.12 | 77 | 6 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 7 | 2019.08.29 | 56 | 7 | 2 | | Хэрэгжих шатандаа 70% |
| 8 | 2020.01.31 | 12 | 8 | 1 | | Хэрэгжих шатандаа 90% |
| | | | 9 | 2 | | Хэрэгжих шатандаа 90% |
| | | | 10 | 3 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 9 | 2020.03.10 | 19 | 11 | 2 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 10 | 2021.05.20 | 35 | 12 | 2 | | Хэрэгжих шатандаа 50% |
| 11 | 2021.04.26 | 30 | 13 | 2 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 12 | 2021.07.08 | 05/05 | 14 | 1 | | Хэрэгжих шатандаа 70% |
| 13 | 2021.11.08 | 66 | 15 | 1 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 14 | 2022.01.28 | 08/04 | 16 | 2 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 15 | 2022.09.23 | 13/03 | 17 | 1 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 16 | 2023.02.10 | 16/04 | 18 | 1 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 17 | 2023.06.27 | 20/04 | 19 | 2 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 18 | 2023.09.27 | 22/02 | 20 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 19 | 2023.11.30 | 23/10 | 21 | 2 | | Хэрэгжих шатандаа 70% |
| 20 | 2024.01.29 | 24/01 | 22 | 2 | | Хэрэгжих шатандаа 70% |
| 21 | 2024.01.29 | 24/02 | 23 | 1 | | Хэрэгжих шатандаа 90% |
| Биелэлтийн дүн /хувь/ | | | | | | 86,5% |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэмдэглэл | | | | | | |
| 22 | 2017.04.10 | 02 | 24 | 1 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 23 | 2022.05.10 | 03 | 25 | 2 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| Биелэлтийн дүн /хувь/ | | | | | | 95% |
| Хоёр. Аймгийн Засаг даргын захирамж | | | | | | |
| 24 | 2019.06.07 | A/400 | 26 | 1 | | Хэрэгжих шатандаа 90% |
| 25 | 2021.11.12 | A/561 | 27 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 26 | 2022.02.16 | A/69 | 28 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 90% |
| 27 | 2023.03.04 | A/95 | 29 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 28 | 2023.05.31 | A/283 | 30 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 29 | 2024.08.02 | A/597 | 31 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| 30 | 2024.03.13 | A/193 | 32 | 1 | | Бүрэн хэрэгжсэн 100% |
| Биелэлтийн дүн /хувь/ | | | | | | 97,1 |
| Нийт хувь | | | | | | 92,6% |

ХЯНАСАН ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА  Т.БАТ-ӨЛЗИЙ
БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН  Т.МӨНХЗУЛ



ЕСӨНЗҮЙЛ СУМАНД ХЭРЭГЖИЖ БҮЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ
ЗАСАГ ДАРГЫН ШИЙДВЭРИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ
(2024 он)

| 2024.10.08 | | 2013 | | 2015 он | |
|--|-------------------|--|---|--|--------------------------------------|
| Шийдвэрийн дэс | Зүйл, заалтын дэс | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Хэрэгжилтийн явц | Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтас хасуулах тухай санал) | Тасарсан болон удааширч буй шалтгаан |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ | | | | | |
| 1 | 1. | 2013.03.14 Дугаар 21 Аймгийн музей, сумдын орон нутаг судлах танхим, Шанхын баруун хүрээ хийдийн үзмэр, эд өлгийн зүйлсийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах тухай. 2.Сумдын орон нутаг судлах танхимын тохижилт үзмэрийн дэглэл, хадгалалт хамгаалалтыг сайжруулан, дохиоллын систем нэвтрүүлэх, орон нутгийн соёлын өвийг сурталчлах төв болгон хөгжүүлэхэд бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлэн, шаардлагатай хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Орон нутаг судлах танхимд Соёлын төвийн зүгээс иргэдийн гар дээр байгаа зүйлийг бүртгэн авч музейн үзмэрийг нэмэгдүүлж байгаа. Үүнд: Готовын Цэрэндулам нэг оёдлын машин өгч ОНСТ-д байршуулсан. ОНСТ-аар үйлчлүүлсэн иргэдийн тоо 2024 оны 10 сарын байдлаар Жуулчин-5 Том хүн-36 Хүүхэд- 23 үйлчлүүлсэн байна. 9-сарын 1 өдөр сумын засаг дарга Т.Бат-Өлзий орон нутаг судлах танхимд нэгдүгээр ангид элсэн орж байгаа хүүхдүүдэд Өндөр гэгээн ЗАНАБАЗАР-ын талаар хичээл орж нийт 18 сурагч 23 эцэг эх хамрагдав. "Орон нутаг хөгжүүлэх сан"-гийн хөрөнгөөр Орон нутаг судлах танхим"-д хөрөнгө оруулсан зүйл байхгүй. | 70 | Н |
| 2 | 2. | 2015.07.03 Дугаар 53 Хүүхэд хамгааллын бодлого батлах тухай. (2015-2024) 3."Хүүхэд хамгааллыг бодлого"-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үе шат тус бүрээр гаргаж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг нийгмийг | Хүүхэд хамгааллын бодлого"-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд Сумын хүүхдийн төлөөх зөвлөл нь жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг ханган ажил байна. Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага Эрүүл мэндийн төв нь хүүхэд хамгааллын бодлогыг үйл ажиллагаандаа мөрддөг болгож албан байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлого | 100 | Н |

| | | |
|--|--|---|
| | <p>хөгжүүлэх үндсэн чиглэл, орон нутгийн төсөвт тусган батлуулж, олон улсын байгууллага, хандивлагчдын зээл тусламжаар хэрэгжих хөтөлбөр төсөлтэй уялдуулан шийдвэрлэж, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллага, иргэдэд сурталчлан таниулж, мөрдүүлж ажиллахыг аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p> | <p>баталгаажуулж жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. ЗДТГ нь Хамтарсан багийн самбар ЕБС, СӨББ нь хүүхэд хамгааллын бодлогын самбарыг байршуулан мэдээллийг шинэчлэн байршуулж тогтмолжсон байна. Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагуудыг чадавхжуулах, дэмжих, мэргэшүүлэх, хүүхдийн оролцоотой дотоодын хяналт, үнэлгээний тогтолцоог бий болгох хүрээнд: Сурагчдын авьяас чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, амьдрах чадварт сургах зорилгоор сургуулийн хүрээнд хөгжүүлэх дугуйлан, секц, хүүхдийн өөрөө удирдах байгууллага нь чиглүүлэгч багшийн хамт дотуур байр, сургуулийн орчинд сургалт, үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан бөгөөд нийт сурагчдын 78% нь дугуйлан секцэд хамрагдаж байна.</p> <p>Нэг сургууль 10 клуб аян сайн хэрэгжиж сургууль дээр 7 ХӨУБ-ын үйл ажиллагаа амжилттай ажилж байна. Сургууль, цэцэрлэг болон хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллага бүр болзошгүй эрсдэлээс хүүхдийг хамгаалах арга зүйд суралцаж, гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөө, аюулгүй бүсийн зураглал гарган хэрэгжүүлэх, хүүхдийн сурч хөгжих, амьдарч буй орчинд ногоон бүс байгуулах, байгаль экологид ээлтэй өсвөр үеийг бэлтгэх хүрээнд: Сургуулийн орчинд суралцагчийг үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх 1 сарын аяныг зохион байгуулсан бөгөөд удирдамжийн дагуу, "Цахим орчны сөрөг нөлөөлөөс урьдчилан сэргийлэхэд хүүхэд бидний оролцоо" илтгэлийн уралдааныг зохион байгуулж нийт 24 хүүхэд оролцсоноос сурагч Б.Анундарь түрүүлсэн. Мөн "Дээрэлхэлтийн эсрэг хамтдаа тэмцье" гар зургийн уралдааныг зохион байгуулахад нийт 100 гаруй сурагчийн бүтээл ирсэн бөгөөд сурагчдаас санал асуулга авахад үе тэнгийнхний дээрэлхэлтийн хувь буурсан үзүүлэлтэй байна. 2023-2024 оны хичээлийн жилийн үйл ажиллагаа эхэлсэнтэй холбоотой 2018 оны 05 дугаар сарын 01-ны өдөр Дугаар А/239 журмын дагуу хүүхэд хамгааллын багийг томилон ажиллуулж цэцэрлэгийн 4 бүлгүүдийн дунд "Гараас гарт" журмын дагуу аяныг зарлан хэрэгжүүлж байна. Бүлгүүдийн хүүхдүүдийг өглөө оройд цэцэрлэгтээ хүлээлгэн өгсөн болон хүлээж авсан эцэг эх, асран хамгаалагчдын гарын үсгийг зуруулан баталгаажуулах ажлыг тогтмол явуулсан. Цэцэрлэгийн гадаад орчны эрсдэлгүй байдал болон хүүхдийн эрүүл аюулгүй амьдрах талаар хяналт тавьж ажиллаа. Ойр орчны онгорхой нүх шуудуунд унахаас сэргийлэх болон зам дагуух хугарч сэртэйсэн хашлага хайсыг засаж янзлах тал дээр анхаарч ажиллаж байна. Гэр</p> |
|--|--|---|

| | | | |
|--|--|--|---|
| | | | <p>хорооллын гудамж талбайн гэрлийн таггүй шон, ил задгай цахилгааны утаснаас урьдчилан сэргийлэх гэмтэж бэртэхээс болгоомжилж үр хүүхдийнхээ эрүүл аюулгүй орчныг нэн тэргүүнд анхаарч эрсдэлээс сэргийлэх тал дээр эцэг эхүүдэд мэдээлэл хийлээ. Цэцэрлэгийн орчинд хог хаягдалгүй, цэвэр байх тал дээр анхаарч ажиллаж байна.</p> <p>“Дотуур байр” хүүхдийн хөгжил, хүмүүжил, төлөвшлийн төв байх орчин нөхцлийг бүрдүүлэх, өнөөгийн бодит байдалд судалгаа шинжилгээ хийж, шинээр барих, засварлах, тохижуулах хүрээнд: Сумын Гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, хамтарсан баг хамтран “ДОТУУР БАЙР”-ны үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөн туслах, санал бодлоо солилцох цаашид тусган хэрэгжүүлэх ажлыг тандах зорилгоор Эцэг эхийн хараа хяналт хол байгаа сурагчид, Дотуур байранд хөтлөгддөг баримт бичиг, Телекамерийн бичлэгийн хэвийн ажиллагаа, камерийн хяналтын дэвтэр хөтлөлт, Хүүхэд хамгааллын бодлогын чиглэлээрх ажилуудтай танилцан дотуур байрны дунд болон ахлах ангийн сурагчдын дунд танин мэдэхүйн АХА тэмцээн зохион байгуулж 1-3-р ангийн сурагчдад чөлөөт цагаа ном уншихийг уриалж үлгэрийн ном гардуулан өгч ажиллалаа.</p> <p>Сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь Теле хяналтын камерын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахаас гадна камер хяналтын хувиар гаргаж өдөр бүр тэмдэглэл хөтлөн ажиллаж байна. Цэцэрлэгийн орчинд 7 камер хэвийн ажиллагаатай ажиллаж байна. Сумын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 8 байгаа. Үүнээс байнгын асаргааны тэтгэмжид 6 хүүхэд хамрагдаж 1 хүүхэд зайны сургалтад хамрагдан явж байна.</p> <p>Анги удирдсан багш болон нийгмийн ажилтан 2023-2024 оны хичээлийн жилийн эхэнд сурагчдын гэрээр айлчлан сурагчдын эрсдлийн үнэлгээг тодорхойлсон бөгөөд Өвөрхангай аймгийн “Багш айлчлал” цахим платформд бүх сурагчдын мэдээллийг бүрэн оруулж баталгаажуулсан мөн анги удирдсан багш нар сурагчдын эцэг эх, асран хамгаалагч, сургуулийн захиргаатай хамтран гуравласан гэрээг хүүхэд бүрийн онцлог, хүмүүжил төлөвшилд тулгуурлан байгуулж хамтарч ажиллаж байна. 2023-2024 оны хичээлийн жилд ахлах ангийн 5 сурагчид нь хараа хяналтгүйгээр зүй бус үйлдэл гаргасныг сумын цагдаагийн газарт мэдэгдэн засаг даргаас албан</p> |
|--|--|--|---|

| | | | |
|--|--|--|---|
| | | | <p>мэдэгдэл ирсний дагуу Сануулах бичигт эцэг эх, асран хамгаалагчдаар гарын үсэг зуруулж хариуг хугацаанд нь хүргүүлсэн. Анги удирдсан багш нар ангийн сурагчдыг нийт 53 үзүүлэлтээр эрсдлийн үнэлгээ хийсэн бөгөөд нийт 350 сурагч хамрагдсанаас эрсдэлгүй 126, бага эрсдэлтэй 146, дунд эрсдэлтэй 41, өндөр эрсдэлтэй 27 сурагч тодорхойлогдсон. Өндөр эрсдэлтэй 27 сурагчийн эцэг эх, асран хамгаалагчтай уулзан гуравласан гэрээнд тусгайлан заалтыг тусгаж эрсдлийг бууруулах үйл ажиллагааг сургуулийн хамтарсан багтай хамтран зохион байгуулж байна. Мөн дунд эрсдэлтэй 41 сурагчийн гэрээр дахин айлчлах, эрсдлийг дахин тодорхойлох үйл ажиллагааг анги удирдсан багш нар хийж байна. 2023-2024 оны хичээлийн жилд тус сургуульд хэл ярианы бэрхшээлтэй 1, хөдөлгөөний бэрхшээлтэй 1, оюуны буюу сэтгэцийн бэрхшээлтэй 3 нийт 5 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч байгаа бөгөөд 2 хөгжлийн бэрхшээлтэй сурагчид анги удирдсан багш ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр хичээлийг орж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй тусгай хөтөлбөрөөр ажиллаж байгаа багшид хуулийн дагуу 10% нэмэгдэлийг өгөх шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Сум багт ажиллаж байгаа Хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах, арга зүйгээр тогтмол хангах хүрээнд: Сумын хамтарсан баг нь жилийн ажлын төлөвлөгөө батлан шинэ гишүүдтэйгээ нууцын гэрээ байгуулан гишүүдийн мэдээ тайлан судалгааг хүн тус бүрээр тухайн хугацаанд нь гаргуулан ажлын уялдаа холбоог нэгтгэн хамтран ажиллаж байна. Тусгай 108 дугаарт мэдээлсэн бодит кейс дээр хамтарсан багаараа асуудлыг аль болох эерэг талаас нь шийдвэрлэх, холбон зуучлах ажлыг зохион байгуулан ажилдаг. 2024 оны байдлаар 108 тусгай дугаарт ирсэн 1 кейсыг шийдвэрлэж хаасан. Сумын өндөр эрсдэлд байгаа 5 хүүхдийг дотуур байранд байршуулан эрүүл мэндийн үзлэг, боловсролын үйлчилгээнд хамруулаад байна. Хамтарсан багт ирсэн зорилтод бүлгийн эргэх холбоотой ажилладаг 1 кейс, Гэр бүлийн харилцааны зөрчилтэй 1 кейс, үйл хайхрах хүчирхийллийн 3 кейс, шийдвэрлэж, хүүхдийн мөнгөтэй холбоотой-4 өргөдөл ирсэнээс 2 өргөдлийг хэлэлцэн шийдвэрлэж 2 өргөдөл нь өөр аймаг, суманд харъяалагдах тул манайх шийдвэрлэх боломжгүй гэдгийг эргэн мэдүүлж заавар зөвлөгөө өгөн ажиллаа. хаасан байна. Сургуулийн хүүхэд хамгааллын баг нь өндөр эрсдэлтэй байгаа 27 сурагчтай хамтарч ажиллахаас гадна 4 хүүхдийг сумын хамтарсан багийн</p> |
|--|--|--|---|

| | | | | |
|---|----|---|--|--|
| | | | <p>хэмжээнд кейс нээн хамтран ажиллаж дотуур байр, цэцэрлэгт хамруулан боловсролын үйлчилгээг үзүүлж байна. Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын баг нь эрсдэлт нөхцөлд байгаа хамтарсан багаар хэлэлцсэн 1 хүүхэд, эцэг эхийн хараа хяналтаас хол байгаа хүүхдүүдийг багш нарын хяналтад авч цэцэрлэгт хамруулан боловсролын үйлчилгээг үзүүлж байна. Тус хүүхдүүдэд өөрийгөө хамгаалах болон өөрийгөө илэрхийлэх аргад сургах чиглэлээр түлхүү ажилладаг. 2024 оны байдлаар Хамтарсан багийн үйлчилгээг 6 хүүхэд үзүүлээд байгаа. Үүнээс сургуулийн дотуур байран 4 хүүхэд сурч байна. 1 хүүхэд цэцэрлэгт 1 хүүхэд гэрээр байна.</p> <p>2024 оны байдлаар Хүүхэд хамгааллын хамтарсан баг нь 6 хүүхдийн асуудлыг шийдвэрлэсэн байна. Хүүхдийн тусламжийн 108 утсанд хандсан гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага мэдээлэл бүртгэгдээгүй байна.</p> <p>2023.05.16-ны 01/566 тоот шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан тоотын хүрээнд ял оногдуулахгүйгаар 01 жилийн хугацаанд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авч тус хугацаанд зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэн албадлагын арга хэмжээ авсан 2 хүүхдэд зан үйлд нөлөөлөх сургалт болон засрал хүмүүжилд хяналт тавьж энэ талаарх тайлан мэдээг пото зурагаар баримтжуулан сар бүрийн төлөвлөгөө боловсруулан ажиллаж тус хэрэг хаагдсан байна. Цаг агаарын аюулт нөхцөл байдлын үед хүүхдийг</p> | |
| 3 | 3. | <p>2016.10.24 Дугаар 61 Журам батлах тухай (School police)</p> <p>2. "School police" эргүүлийн ажиллах журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Я.Ганбат), журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл урлагийн газар (Ч.Самбуу-Ёндон), Ерөнхий боловсролын сургуулиудад үүрэг болгосугай.</p> | <p>2016</p> <p>БСШУСС-ын 2018 оны А/398 дугаар тушаалын дагуу тус сургуулийн бага ангийн сурагчдын эцэг эхчүүд эцэг эхийн эргүүл жижүүрийг анги удирдсан багшийн гаргасан хуваарийн дагуу хийж гүйцэтгэж байна. Тус эргүүл жижүүр нь өглөө 9⁰⁰-13⁰⁰, 13⁰⁰-18⁰⁰ цаг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэдэг бөгөөд жижүүр хийж буй эцэг эх, асран хамгаалагч нь дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэдэг. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тухайн өдрийн сургалт хүмүүжлийн ажилд хөндлөнгийн хяналт тавьж ажилладаг. 2. Бага ангийн сурагчдын завсарлагааны дэг журамд хяналт тавьж ажиллахын зэрэгцээ цэвэр, бохирын ухсан нүхэнд сурагчид унах бэртэхээс сэргийлж тэдэнд сануулга, зааварчилгааг тогтмол өгч ажилладаг. | |

| | | | |
|----------------|---|---|-----|
| | | <p>3. Хичээл тарах болон өдрийн ээлжийн хичээл эхлэх үед сурагчдыг зам тээврийн осолд өртөхөөс сэргийлэн 1-2-р ангийн сурагчдыг анги удирдсан багштай хамтран гараас гарт хүлээлгэн өгөхөд тусалдаг.</p> <p>4. Сургуулийн орчинд гарсан зөрчлийг холбогдох албан хаагчид мэдээлэх болон зөрчил гарахаас урьдчилан арга хэмжээнүүдийг авч ажилладаг.</p> <p>5. Бага ангийн сурагчдын үдийн хоолны чанарт хяналт тавьж, тэмдэглэл хөтөлдөг.</p> <p>6. Сургалтын байгууллагад гаднаас нэвтрэх иргэнийг ямар зорилгоор, хэнтэй уулзах талаар асууж холбогдох багш, ажилтан, албан хаагчийн анги болон өрөөг зааж өгч тусалдаг.</p> <p>Эргүүл жижүүр хийх хугацаандаа гүйцэтгэсэн үйл ажиллагааны талаар дэвтэрт тэмдэглэн хөтлөн хантаазны хамт дараагийн жижүүр хүлээлгэн өгдөг болно.</p> | |
| 2018 он | | | |
| 4 | <p>2018.06.27 Дугаар 08/02 Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдуулах албан татварын хэмжээг тогтоох тухай</p> <p>2. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хэмжээг мөрдүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Г.Ганболд)-д үүрэг болгосугай.</p> | <p>2024 оны төлөвлөгөө нь 9,500,000 төгрөг хуримтлуулах бөгөөд, нийт 2024 оны 10 сарын байдлаар нийт 250 авто машины Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдуулах албан татвар 13,030,893.58 төгрөг орсон байна.</p> | 100 |
| 5 | <p>2018 Дугаар 36 Сум хөгжүүлэх сангийн журмын хэрэгжилтийн тухай</p> <p>Аймаг, сумын Засаг дарга нар болон аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газарт даалгасан.</p> | <p>ЖДУ хариуцсан мэргэжилтэн Сумын хоршоо хөгжүүлэх сангаас зээл олголтын 2024 оны 04 дүгээр сард нийт 2 хоршоонд нийт 115,000,000 төгрөгний зээлийг олгосон. 2024 оны 10 дугаар сарын байдлаар зээл олгохоор мэдээллийг олон нийтийн сүлжээнд байршуулан ажиллаж байна. Сум хөгжүүлэх сангийн зээлд 2024 оны 10 дугаар сарын өссөн байдлаар зээлийн эргэн төлөлт өссөн байдлаар 67,924,101 төгрөгний төлөлтийг хийгдсэн байна. Нийт сумын хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэл 5 аж ахуй нэгж, хоршоо, 14 иргэдийн 254,200,255 төгрөгний үлдэгдэлтэй байна.</p> | 90 |

| | | | | |
|---|----|---|---|-----|
| 6 | 6. | <p>2018.11.12 Дугаар 77 Аймгийн хөтөлбөр батлах тухай (Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр 2019-2024) 2.Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталж, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (Г.Ганболд)-д даалгасугай.</p> | <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлж буй санхүүгийн дэмжлэгт 4 эмэгтэй, малжуулах хөтөлбөрт 10 эмэгтэй, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлд 2 эмэгтэй хамрагдаж байнгын ажлын байртай болсноос гадна сэг зэм устгах цэвэрлэгээний нийтийг хамарсан ажилд 8 эмэгтэй хамрагдаж түр ажлын байраар хангагдсан. Мөн аж ахуйн нэгж албан газарт 4 эмэгтэй ажилд зуучлагдан орон одоогоор ажиллаж байна. Мөн санхүүгийн дэмжлэгт хамрагдаж буй иргэд аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамрагдсан байгаа. Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 6 эмэгтэй ажлын байртай болсон.</p> | 100 |
| 7 | 7. | <p>2019.08.29 Дугаар 56 Хөтөлбөр батлах тухай. (Хүмүүнлэгийн дэд хөтөлбөр 2019-2024) 2. Хүмүүнлэгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүхий л талын туслалцаа дэмжлэг үзүүлэн зохион байгуулалтын арга хэмжээ авч, Улаан загалмайн үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулахтай холбогдсон зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган ажиллахыг аймгийн Засаг дарга (Г.Ганболд), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.</p> | <p>Сумын анхан шатны Улаан загалмайн хорооноос сумын гамшгаас хамгаалах штабтай хамтран гамшгийн үед ард иргэдийн амь насыг гамшгаас хамгаалах, ослоос урьдчилан сэргийлэх, аюулт үзэгдэл тохиолдсон үед нөхөн сэргээх ажлыг хурдан хугацаанд зохион байгуулах, гамшгийн үед иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, гамшгийн бэлэн байдлыг хангах, мэдлэг чадварыг нэмэгдүүлэх, хариу арга хэмжээ авах талаар сургалтуудыг зохион байгуулж ажилласан.</p> | 70 |
| 8 | 8. | <p>2020.01.31 Дугаар 12 Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 11/01 дүгээр тогтоолоор батлагдсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор хог, хаягдал боловсруулах үйлдвэр барих асуудлыг судлан шийдвэрлэх, энэ чиглэлээрх санал, санаачлага, төсөл хөтөлбөрийг дэмжиж ажиллахыг аймгийн Засаг дарга (Г.Ганболд)-д үүрэг болгосугай.</p> | <p>Хог хаягдлын тухай хуулийн 9.4.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд сумын хэмжээнд 2024 оны бүх нийтийн 1 дүгээр улирлын их цэвэрлэгээг 2024 оны 04 дүгээр сарын 19-нд Засаг Даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Сургуулийн Өмнөх Боловсролын Байгууллагуудыг өргөн хүрээнд хамруулж зохион байгуулж ажиллалаа. Мөн сумын төвийн айл өрхүүдэд өөрийн эзэмшлийн талбайн хог хаягдлыг цэвэрлэхийг уриалан хамтран ажиллалаа. Энэхүү ажлын хүрээнд нийт 53 тонн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаясан байна. Сумын төвийн хэмжээнд 5 хүнсний дэлгүүр үйл ажиллагаа явуулдаг ба хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах үйл ажиллагааг дэмжиж, мэдээлэл солилцож хамтран ажиллахаар болсон. Ажлын хүрээнд 3 хүнсний дэлгүүр гаднах талбайдаа ангилан ялгах зориулалт бүхий хогийн савыг байршуулж үйл ажиллагаагаа явуулж байна. 2024 оны 10</p> | 90 |

| | | | | | |
|--|-----|---|---|----|--|
| | 9. | 2. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай. | сарын байдлаар нийт 90 тн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаясан байна. | 90 | |
| | 10. | 3. Ус хангамж, ариутгах татуургын эрүүл ахуйн бүс болон хамгаалалтын зурваст газар олгохгүй байх, инженерийн шугам, сүлжээний төлөвлөлтийг жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах, шинээр байгуулагдаж байгаа хасагдаж байгаа инженерийн шугам, сүлжээ болон байгууламжийн эрүүл ахуйн бүс, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг тухай бүр тогтоож кадастрын зураглалд оруулан мэдээллийн сан үүсгэх ажлуудыг зохион байгуулж ажиллахыг ашиглагч байгууллага болон аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай. | Сумын хэмжээнд хогийг ангилан ялгах пресслэгч машиныг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр авч тохижилт үйлчилгээний ажилтанд хүлээлгэн өгөн хог хаягдлыг ангилан ялгалтыг эхэлсэн боловч техникийн саатлаас болоод түр зогссон байна. Эмнэлгийн хог хаягдлыг цуглуулах уут сав, аюулгүй хайрцагыг эмийн тендэрт захиалан хангалттай авч, хар уутанд ердийн, шар уутанд халдвартай хог хаягдлыг цуглуулж, аюулгүй хайрцаганд тариур, амплу зэргийг хийж нээсэн он сар өдрийг тодорхой бичиж, 3/2 хэмжээнд хүрмэгц шатааж устгаж байна. Жилд дунджаар аюулгүй хайрцаг 250 ширхэгийг хэрэглэж байна. ЭМТ-ээс гарч буй эмнэлгийн болон ердийн хог хаягдлыг ангилан ялгаж хэмжээг тодрхойлон, бүртгэл маягтыг журмын дагуу хөтлөж, хүний эрүүл мэндэд хоргүйгээр устгаж байна. Мөн хөдөлмөр халамж үйлчилгээний мэргэжилтэн, 4 багийн Засаг дарга нартай хамтран хүнсний эрхийн бичиг авдаг 18 иргэнийг 2 өдөр 3 хэсэг болгон хувааж, сумын төвийн баруун, зүүн голын голдрилууд, Арлын ухаагаас Бумбатын хөтөл ортол улсын чанартай авто зам дагуух сэг зэм, хог хаягдлыг цэвэрлэж нийт 5 тонн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаяж, устгалд оруулсан. | 90 | |

2021 он

| | | | |
|-----|--|---|----|
| 11. | <p>2021.05.20 Дугаар №35 Шатар хөтөлбөр батлах тухай /2021-2024/ 2. Шатар хөтөлбөрийг сум, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх удирдлагаа, зохион байгуулалтаар хангах.хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөл хөтөлбөрийн санхүүжилтэд тусган ажиллахыг сумын Засаг дарга нарт, шатрын спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт тус тус даалгасугай.</p> | <p>Ахмад настны зөвлөн туслах үйлчилгээ хөтөлбөрийн хүрээнд ахмад настан О.Хандмаа нь шатарын дугуйланг хичээллүүлэхээр гэрээ байгуулсан. Мөн сургуулийн Номын санд шатарын булан байгуулан сурачид чөлөөт цагаараа шатар тоглож хэвшээд байна.</p> | 50 |
| 10 | <p>2021.04.26 Дугаар 30 Хөтөлбөр батлах тухай (Амар тайван Өвөрхангай 2021-2024) 2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, хөтөлбөрт хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгасугай.</p> | <p>Амартайван Өвөрхангай хөтөлбөрийн хүрээнд сумын хэмжээнд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуй нэгж байгууллагуудад хяналт тавьж, өдөр оройн эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаандаа тогтмол шалгаж архи согтууруулах ундаа худалдан борлуулахгүй байх тал дээр хяналт тавьж ажиллаж байна. 2024 оны 10 дугаар сарын байдлаар нийт Олон нийтийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж байх хугацаандаа согтууруулах ундаа хэрэглэсэн нийт 13 хүнийг ар гэрт нь хүлээлгэн өгч анхааруулага хүргэн ажилласан байна. Мөн 21 нас хүрээгүй, эсхүл согтуу хүнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхгүй байх тал дээр хяналт тавьж. Сумын гудамж, талбайд өдөр, шөнө тодорхой цагуудад олон нийтийн эргүүлийн хамт хяналт шалгалтыг хийж ажиллаж, нийтийн хэв журам зөрчих, гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гарах явдлаас урьдчилан сэргийлж ажиллаж байна. Мөн улсын төлөвлөгөөт ажил болон бусад нийтээр дагаж мөрдөх өдрүүдэд сумын Засаг даргын захирамжаар Согтууруулах ундаа худалдаалдаг аж ахуй нэгжүүдэд тооллого явуулан хориглох арга хэмжээг цаг тухай бүрт нь авч ажиллаж байна.</p> | 90 |
| 11 | <p>2021.06.07 Дугаар 37 Хөтөлбөр батлах тухай (Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 2021-2024) 2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажиллагааны төлөвлөгөөг батлан, шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлж, хөтөлбөрт хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д даалгасугай.</p> | <p>Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болшгүй гэр бүл, эрсдэлт нөхцөлд буй хүүхдүүдийн судалгааг жил болгон сумын Цагдаагийн хэсэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хамтарсан багийн гишүүдтэй хамтран шинэчлэн ажиллаж байна. Жил болгон мэргэжилтэний мэдээллийн санг шинэчлэн бүрдүүлж зохих байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Нийгмийн эрүүл мэндэд гэр бүлийн хүчирхийллийн үзүүлж буй хор нөлөө осол гэмтэл, түүнээс үүсэх өвчлөлийн шалгааныг тодорхойлон иргэдэд энэ талаарх ойлголтыг сурталчилан ажиллаж байна. Эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан болон хамтарсан баг</p> | 90 |

| | | | |
|---------|-----|--|----|
| | | хамтран хүчирхийлэлд өртсөн байж болшгүй хүүхдүүдийг хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэгээр тодорхойлоход хагас жилийн байдлаар хүчирхийлэлд өртсөн шинэ тэмдэг илэрсэн хүүхэд урьдчилан сэргийлэх үзлэгээр гараагүй байна. Цаашид 0-18 насны хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэг үргэлжлэн явагдах тул хамтран үзлэг оношлогоонд хяналт тавин ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг Ерөнхий боловсролын сурагчдын дунд Дотуур байр, ахлах анги, дунд анги хэмээн хэсэгчлэн 3 удаа Сумын цагдаагийн хэсэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нартай хамтран зохион байгуулаад байна. | |
| 12 | 14. | 2021.07.08 Дугаар 05/05 Сум дундын отрын нөөц нутаг, түүний хилийн зааг тогтоох тухай 1. Сум дундын 626 312.6 га отрын нөөц нутгийг зохистой ашиглах, хамгаалах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулахыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д даалгасугай. | 70 |
| 13 | 15. | 2021.11.08 Дугаар 66 Хөтөлбөр батлах тухай /2021-2024/ Нэг өрх- Нэг ажлын байр Орон нутгийн зорилтод бүлгийн иргэдэд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, салбар дундын уялдаа холбоонд тулгууран хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлж, нэг өрхөд нэг ажлын байр бий болгох замаар тэдгээр өрхийн амьдралын чанарыг сайжруулах | 90 |
| 16. | 16. | 2022.01.28 Дугаар 08/04 “Сумдын газрын үнэлгээний бүсийн зураг, итгэлцүүр, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 2. Газрын төлбөрийн бүсчлэл, итгэлцүүр, газрын төлбөрийн хэмжээг мөрдүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж | 90 |
| 2022 он | | | |
| | | Хөтөлбөрт хамрагдсан иргэдээс 18 иргэн байнгын ажлын байранд, түр ажлын байранд давхардсан тоогоор 24 иргэн хамрагдаад байна. Малжуулах хөтөлбөрт хамрагдсан 5 өрхийн 10 малчин, Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 2 иргэн, тус тус аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамрагдсан. Байнгын ажлын байранд хамрагдсан иргэдээс 4 иргэн албан журмын даатгалд 14 иргэн сайн дурын даатгалд хамрагдаж байна. Хөтөлбөрт хамрагдсан иргэд иргэний бичиг баримтын зөрчилгүй болж нийгмийн сурь үйлчилгээндээ хамрагдаж байгаа. | |
| | | Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 8 дахь удаагийн сонгуулийн ээлжит 5 дугаар хуралдааны 01 тогтоолоор газрын төлбөрийн суурь үнэ итгэлцүүр төлбөрийн хэмжээг батлуулан мөрдлөг болгон ажиллаж байна. Уг тогтоолоор бэлчээрийг 265 төгрөг, хадланг 375 төгрөг, атаршсан газрыг 1491 төгрөг, Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн газрыг 60 төгрөг, барилга байгууламжийг доорх газрыг 100 төгрөгөөр суурь үнийг тогтоон ажиллаад байна. Мөн хөдөө аж ахуйн үйлдвэрийн зориулалтаар 4200, хот тосгон 5180, | |

| | | | | | |
|-----|--|--|---|----|--|
| 15 | | <p>ажиллахыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д үүрэг болгосугай.</p> | <p>худалдаа үйлчилгээ 10.0 хөдөө аж ахуйгаас бусад үйлдэрийн зориулалтаар 8000, шугам сүлжээ 7500 тегрегөөх тус тус тогтоогоод байна.</p> | | |
| 17. | | <p>2022.09.23 Дугаар 13/03 “Хөтөлбөр батлах тухай”</p> <p>1.Өвөрхангай аймгийн “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, үр чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.</p> <p>2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, арга зүйгээр ханган, шаардагдах хөрөнгийг эрүүл мэндийн салбарын төсөвт жил бүр тусган ажиллахыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д даалгасугай.</p> | <p>MNS5081:2013 Сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа стандартаар ажиллалаа. Хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр эрүүл мэндийн төв нь 4 их эмч 5 сувилагч, 4 мэргэжилтэн, ажилчид 10 бөгөөд нийт эмч мэргэжилтний мэдлэг үр чадварыг дээшлүүлэх, ажлын байранд ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дотоодын сургалтын төлөвлөгөө боловсруулан сар бүр сургалт зохион байгуулж байна. Мөн Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/566 дугаар тушаал, 274 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтын дагуу ижил мэргэжилтний үзлэгийг улирал бүр зохион байгуулж үр дүнг хэлэлцэн арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Ингэснээр эмч мэргэжилтний мэдлэг үр чадвар сайжирч өвчин эмгэгээс урьдчилан сэргийлж оношилгоо эмчилгээний чанар хүртээмж сайжирсан. Сүүлийн 5 жилээр хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт, байгууллагын хүний нөөц, багаж тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтүүдээр мэдээний сан үүсгэж, тухай бүр баяжуулалт хийж ажиллаж байна. Байгууллагын хүний нөөцийн хувьд жил ирэх тусам бүтэц орон тоо нэмэгдэж сүүлийн 1 жилд сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн мэдлэг 2 дахин нэмэгдсэн нь иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмж сайжрах гол үндэс болсон. Сэргээн засах, яаралтай тусламж, лаборатори, физик эмчилгээний тоног төхөөрөмжүүдийн хангалт сүүлийн 1 жилд нэмэгдэж тусламж үйлчилгээний нэр төрөл олширсон байна. Хөх болон умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэг, жирэмсний эрт үеийн хяналт зэрэг үзүүлэлт сайжирч аймаг улсын дундаж түвшнээс дээгүүр үзүүлэлттэй байна. Хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтэд сар бүр дүн шинжилгээ хийж баг тус бүрээр үзүүлэлтийг гаргаж байгууллагын удирдлага эмч эмнэлгийн мэргэжилтнүүд, ард иргэдийг мэдээллээр хангадаг бөгөөд тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтүүдийг ажилчдын ажил дүгнэх үзүүлэлтэд оруулж хангалттай сайн үнэлэгдсэн ажилтанг урамшуулах, хангалтгүй үнэлэгдсэн ажилтанд хариуцлага тооцох тогтолцоог нэвтрүүлж ажилласан.</p> | 90 | |

| | | 2023 он | | |
|----|-----|---|---|-----|
| 16 | 18. | <p style="text-align: center;">2023.02.10 Дугаар 16/04</p> <p style="text-align: center;">Зөрчлийн улмаас түр саатуулагдсан тээврийн хэрэгслийн талаар авах зарим арга хэмжээний тухай”</p> <p>1.Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчсөний улмаас түр саатуулагдсан энэхүү тогтоол гарсан өдрөөр түр саатуулах байранд байгаа 2017-2022 оны тээврийн хэрэгсдлүүдийг түр саатуулах байрны хураамж, бусад төлбөрөөс чөлөөлөн буцаан олгох ажлыг эрчимтэй зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга (Г.Чимэддагва)-д даалгасугай.</p> | <p>2024 оны 10 дугаар сарын байдлаар сумын хэмжээнд нийт Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 7 хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүнээс 1 хэрэг шийдвэрлэх шатандаа 6 хэрэг Шүүхийн шийдвэрээр торгуулийн арга хэмжээ авагдан шийдвэрлэгдээд байна. Мөн 2 сарын хугацаанд 50 гаруй удаа улсын чанартай авто зам дагуу постонд үүрэг гүйцэтгэн нийт 13,000,000 гаруй торгуулийг төвлөрүүлээд хүү торгуулийн орлогийг 70 гаран хувьтай биелүүлээд байна.</p> | 90 |
| 17 | 19. | <p style="text-align: center;">2023.06.27 Дугаар 20/04</p> <p style="text-align: center;">“Хөтөлбөр батлах тухай”</p> <p>1.Аймгийн нийт мал сүргийн бүтцийг сайжруулах, үхэр сүргийн тоо толгойг нэмэгдүүлэх зорилгоор “Үхэр сүрэг” хөтөлбөрийг нэгдүгээр, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар, хөтөлбөрийн санхүүжилтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай. 2.“Үхэр сүрэг” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.</p> | <p>Үхэр сүрэг хөтөлбөрийн хүрээнд 2022-2023 оны мал тооллогоор үхрийн тоо толгой 10 хувиар өссөн үзүүлэлтэй байна.Суманд мах сүүний чиглэлийн үхэр өсгөн үржүүлдэг шилмэл сүрэг хоршоонд хоршоо хөгжүүлэх сангаас 50 сая төгрөгний зээлийг олгоод байна. Сумын хэмжээнд Шилмэл сүрэг хоршоо Хайрханы 3 дугаар багийн иргэн О.Ганбат нар нь Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Эрүүл мэндийн төв болон ард иргэдийг 100 хувь сүүгээр ханган ажиллаж байна. Мөн суманд Сэлэнгэ үүлдэрийн бухаар сайжруулалтыг хийгдэж байна.</p> | 90 |
| 18 | 20. | <p style="text-align: center;">2023.09.27 Дугаар 22/02</p> <p style="text-align: center;">Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай</p> <p>1.Аймгийн нутаг дэвсгэрт орших үл хөдлөх эд хөрөнгөд ногдуулах албан татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоосугай 2. Үл хөдлөх хөрөнгийн албан татварыг тогтоосон хувмар ногдуулах ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч (И.Доржсүрэн)-д даалгасугай</p> | <p>Үл хөдлөх албан татвар нь 2024 онд Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын хэмжээнд 7-н ААН, 2-Банк, 1-иргэний 2,400,000 төгрөг төвлөрхөөс 2024 оны 10-р сарын байдлаар Алтан жолооч хүлэг ХХК, Гурван тулгат цагаан хайрхан ХХК, Мөн цагаан толгой ХХК, Бүтэн заяа ХХК, Маналын атистат ХХК, Гурван баян загал ХХК, Баян Үйлст Хайрхан ХХК нарын үл хөдлөх хөрөнгийн албан татвар болох 3,579,242.15 төвлөрөн 10 дугаар сарын байдлаар 124 хувийн биелэлттэй хэрэгжээд байна.</p> | 100 |

| | | | | |
|----------------|-----|---|--|----|
| 19 | 21. | <p>2023.11.30 Дугаар 23/10 Зорилтод жил батлах тухай 1.2024 оныг “Цахим шилжилтийг эрчимжүүлэх” жил болгон зарласугай 2.”Цахим шилжилтийг эрчимжүүлэх” жил болгон зарласантай холбогдуулан орон нутгийн хэмжээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.</p> | <p>Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 18/01 тоот тогтоолын сумын Зорилтод жилийн төлөвлөгөөг 5 бүлгийн хүрээнд 24 зүйл заалттайгаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөнд тусгагдсан тусгайлан бэлтгэгдсэн сургагч багш Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон төрийн албан хаагчид цахим орчины хэрэглээ болон ашиглалтын талаар сургалт мэдээллийг тогтмол хийж ажиллаж байна. Мөн Сумын төвийн болон албан байгууллагуудын камерийг шинэчлэх ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлж ажиллаж байна. Мөн Киоск машины үйлчилгээг иргэдэд хүргэн Иргэний бүртгэлтэй холбогдолтой төлбөрийн асуудал мөн Татварын үйл ажиллагаатай холбоотой төлбөрийг түргэн шуурхай төлөх асуудал шийдэгдэн иргэдийн тогтмол хамруулж хэвшээд байна. Хагас жилийн байдлаар “Цахим шилжилтийг эрчимжүүлэх” зорилтод жилийн тайланг гарган хагас жилийн байдлаар 82,7 хувьтай хэрэгжсэн байна.</p> | 70 |
| 2024 он | | | | |
| 20 | 22. | <p>2024.01.29 Дугаар 24/01 “Жендерийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн үйл явц, үр дүнгийн тухай” 2. Жендерийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг бүх шатанд эрчимжүүлж, үр дүн гаргаж ажиллахыг аймгийн Засаг даргын Үүрэг гүйцэтгэгч (И.Дожсүрэн)-д үүрэг болгосугай</p> | <p>Жендерийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхийг бэхжүүлэх, хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, шийдвэр гаргах түвшинд хүйсийн тэнцвэрт байдлыг хангах хүрээнд: “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай”, “Жендерийн тэгш байдлыг хангах тухай” хуулиудаар иргэдэд сургалтыг танхимаар 2 удаа зохион байгуулж 82 иргэн хамрагдлаа. Мөн жендерийн талаарх ойлголтыг олон нийтэд цахимаар мэдээллийг хүргэн ажиллаж байна. Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага тооцож ажиллах талаар байгууллагын дотоод журманд тодорхой заалтуудыг оруулан биелэлтийг нь ханган ажиллаж байна. Гэртээ эрт харъя аяна хүрээнд Эрэгтэй, эмэгтэй, хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендерийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгааг ЗДТГ, Сумын Эрүүл мэндийн төвийн ажилтан албан хаагчдад Гэр бүлийн харилцаа, гэр бүлийн үүрэг, Тэгш эрх эдэлжтэгш үүрэг хариуцлагатай байхын тухай сургалтыг нийгмийн бодлогын мэргэжилтэн П.Отгончимэг зохион байгууллаа. Мөн Төрийн албан хаагчийн тухай</p> | 70 |

| | | | | | |
|---|-----|---|--|-------|--|
| | | | <p>хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль-д ажилтан албан хаагчийн нийгмийн баталгаа, хүүхдийн эрх хамгааллын чиглэлээрх хууль тогтоомжийн заалтын тухай сургалтыг ЗДТГ-ын Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн сургалт хийж ажиллаа. Жөндөртэй холбоотой заалтыг Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусган, холбогдох албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заалтыг оруулж биелэлтийг ханган ажиллахаар тусгасан байна. Нийгмийн бодлогын мэргэжилтэн нь жөндөрийн эрх тэгш байдлын талаар холбогдох албаны мэргэжилтнээс суралцан удирдлага, байгууллагын хөтөлбөр, бодлого шийдвэрүүдэд тусгуулан ажиллаж байна. Есөнзүйл хэмжээнд жөндөрийн эрх тэгш байдлыг хангах, салбар хороо одоогоор байгуулагдаагүй байна. Албан байгууллагын ажилтан албан хаагчдын хүйсийн тэнцвэрт байдлын судалгааг гарган холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн. Жөндөрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аянд нэгдэх уриалтыг албан байгууллагын, аж ахуйн нэгжийн зарын самбар, үйл ажиллагаа явуулж буй албан байгууллага аж ахуйн нэгжүүдийн өрөө тасалгааны хаалган дээр нааж мөн самбар болон цахим хаягт байршуулан, аянд нэгдэж үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хамтран ажиллах талаар зөвлөгөө мэдээлэл хийж ажиллаа.</p> | 90 | |
| 21 | 23. | <p>2024.01.29 Дугаар 24/02 “Журам батлах тухай”</p> <p>1. Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, шинэчилсэн үнэлгээ тогтоох журам”-ыг хавсралтаар баталсугай</p> | <p>Есөнзүйл сумын Өмч хамгаалах байнгын зөвлөл нь нийт 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдөр сумын булаг, шанд, худагнуудад тооллого хийсэн бөгөөд нийт 18 худаг, булаг шандад тооллого хийж шинээр гэрээ байгуулсан. Үүнээс 3-4 худаг эвдрэлтэй байсан. Зөвлөлийн дарга холбогдох хүмүүстэй нь хариуцлага тооцох шаардлагыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга С. Бат-Эрдэнэд албан бичиг хүргүүлсэн. Мөн 2024 оны 6 дугаар сарын 3 ны өдөр сумын нийт төсөвт байгууллагуудад хагас жилийн өмчийн тооллого хийх албан тоот илгээсэн. Холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа тогтвортой явуулан ажиллаж байна.</p> | 86,5% | |
| <p align="center">Бүлгийн дундаж дүн</p> <p align="center">АЙМГИЙН ИТХ-ЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС</p> | | | | | |
| 24. | | <p>2017.04.10. Дугаар 02</p> <p>Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан арга хэмжээ авч ажиллах тухай</p> <p>-Сумдын ОНХС, сум хөгжүүлэх сангаас иргэд, аж ахуйн нэгжийн авсан хугацаа хэтэрсэн зээл, худалдан авах ажиллагааны</p> | <p>Сумын хоршоо хөгжүүлэх сангаас 2024 онд шинэчлэгдсэн журмын дагуу 2 хоршоонд зээл олгосон. Нийт 31 зээлдэгчээс зээлээ бүрэн дарж дуусгасан 12 зээлдэгч үүнээс үлдсэн 5 аж ахуй нэгж хоршоо, 14 иргэн байна. Гэрээний хугацаа дуусгавар болсон 2 зээлийг шүүхэд өгч албадан гүйцэтгүүлэх болсон. Бусад зээлдэгч нар гэрээний дагуу үүргээ гүйцэтгэж байна. Сум хөгжүүлэх сангийн зээлд 2024 оны 10</p> | 90 | |

| | | | | |
|--------------------------------------|----|---|---|-----|
| | | хууль зөрчсөн байдал, зориулалт бусаар зарцуулсан зардлуудын талаар тодорхой ажлын чиглэл гаргаж, зээлийг эргэн төлүүлэх, буруутай хүмүүст арга хэмжээ тооцох, цагдаа, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажиллах. | дугаар сарын өссөн байдлаар зээлийн эргэн төлөлт өссөн байдлаар 67,924,101 төгрөгийн төлөлтийг хийгдсэн байна. Нийт сумын хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэл 5 аж ахуй нэгж, хоршоо, 14 иргэдийн 254,200,255 төгрөгийн үлдэгдэлтэй байна. | |
| 2023 он | | | | |
| 23 | 25 | <p>2022.05.10 Дугаар 03</p> <p>1. "Ахмадын талаар авах арга хэмжээний тухай" 2021 оны 17 дугаар тогтоолыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, эрчимжүүлэх</p> | <p>Сумын Ахмадын хороо нь сумын Засаг дарга, аймгийн Ахмадын хороо Эрүүл мэндийн төвийн Ерөнхий эмчтэй нэг жилийн хугацаатай ажил төрлийн гэрээ байгуулан ажиллаж сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны төсөвт ахмад настнуудад хууль тогтоомж, сумын Хөдөлмөр нийгмийн халамжийн мөргэжилтэнтэй хамтран сургалт зохион байгуулж Эрүүл мэндийн газартай гэрээ байгуулж ажилласны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй ахмад болон гэрээр хэвтэн эмчлүүлж байгаа ахмадуудад хүрч үйлчлэж байна. Бэлгийн тооллын Хаврын тэргүүн сарын шинийн нэгнийг тохиолдуулан бүх ахмадууддаа бэлэг албан байгууллага, аж ахуй нэгж, халамжийн байгууллага өгч хүндэтгэл үзүүллээ. Орон нутагт өвөлжилт хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэн учраас малчиддаа сэтгэлийн дэм ахмадуудаас 420000 төгрөг, 23 нэмнээ, 5 төлийн уут, 26 ширхэг бэлий илгээлээ. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Сумын эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран гар бөмбөг, дардс, цэнгээнт бүжиг хамтран зохион байгууллаа. Мөн багуудын дунд урлаг спортын нөхөрсөг уулзалт тэмцээн зохион байгууллаа. Тэмцээнд 2-р баг 1-р байр, 3-р баг 2-р байр тус тус эзэллээ. 5 дугаар сард ахмадуудынхаа дунд "Бүтээлч ахмад" аян зарлаж ахмадынхаа байрны гадуур сумын засаг даргын дэмжлэгтэйгээр хөрөнгө оруулалт хийж өөрсдийн хүчээр хашаагаа гагнаж, будаж, мод тарьж тохижууллаа. Зүүн 5 бүсийн тэмцээнийг амжилттай зохион байгууллан явууллаа. Софьт волейболын тэмцээнийг 50-59 нас, 60-аас дээш насны ангилалаар, Граньд голф, Ардын дуу, Дуэт дуу, Бүжиг гэсэн урлаг спортын 4 төрлөөр уралдааныг амжилттай зохион байгууллаа.</p> | 100 |
| Бүлгийн дундаж дүн | | | | 95% |
| АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ | | | | |

| | | | | |
|----|----|--|---|-----|
| 24 | 26 | Цахим-Архив хөтөлбөр 2019.06.07 №А/400 | <p>Байгууллага аж ахуйн нэгжийн албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд oig-ams программдээр захирамжлалын баримт бичиг, явуулсан бичиг өргөдөл гомдлыг тус бүрээр шивж оруулан архив, бичиг хэргийг эрхлэгчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд архивын баримтыг цахим тоо хэлбэрт оруулах заалтыг зааж биелэлтийг ханган ажиллаж байна. Байгууллагын бичиг хэргийн ажилтаны албан тушаалын тодорхойлолтонд албан хэрэг хөтлөлтийн талаар аривын бичиг баримтыг цахим хэлбэрт шилжилтыг ханган ажиллаж байна. 2024 оны 10 сарын 21-ны байдлаар Засаг даргын захирамж 115, Засаг даргын Тамгын газрын тушаал 20, өргөдөл гомдол 70, ирсэн бичиг 265-ийг тус тус шивж оруулаад байна. Архивын баримтын хадгалалт хамгаалалт, ашиглалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд Архивын тусгай өрөөтэй, 2 тавиуртай, баримтын данстай гарын авлагаар хангагдсан. Байгууллагын архивт жил бүр баримт бичгийг хүлээн авч хуваарийн дагуу архивын нөхөн бүрдүүлэлтийг хийж ажиллаж байна. Суманд тэмдэглэж буй түүхэн ой онцлог үйл явдлын холбогдолтой баримт бичгийн дүрс бичлэгийг CD дээр буулган файл болон цаасан хэлбэрээр архивт хадгалж байна.</p> | 90 |
| 25 | 27 | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр батлах тухай 2021.11.12 №А/561 | <p>Засаг даргын Тамгын газрын хувьд Үйлчилгээний болон Захиргааны албан хаагчид улирал болон хагас бүтэн жилээр гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг тогтмол олгон ажиллаж байна. Мөн 10 сарын байдлаар нийт давхаргасан тоогоор 32 албан хаагчид 8,919,000 төгрөгийн томилолтыг бодож олгоод байна. Ерөнхий боловсролын сургуулийн хувьд 2 албан хаагчийг сумын төрийн албан хаагчийн байранд оруулсан. Нийт багш ажилчиддаа 1,2,3 дугаар улиралын үр дүнгийн урамшуулалыг 40-45 хувиар бодож олгосон. Мөн гүйцэтгэлийн үнэлгээнд 2-4 дүгээр шатад шалгагдсан 3 багшид улирал бүр урамшууллыг олгон ажиллаж байна. Эрүүл мэндийн төвийн хувьд Эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалтын төлөвлөгөө боловсруулж, эмч мэргэжилтнүүдийг тасралтгүй сургалтанд хамруулж байна. Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэний 2023-2024 оны багц цагийн биелэлт 100%. СӨББ: Эрхлэгч Б.Эрдэнэцэцэг ХАБЭА 2 удаагийн сургалтад хамрагдсан. Нягтлан бодогч Б.Азсүрэн Нягтлан бодогч нарыг чадавхжуулах сургалтад 9 дүгээр сард хамрагдсан Байгууллагын жирэмсний амралт авсан болон ажлаас гарсан түр орон тоон дээр ажиллах дотоод шилжилт хөдөлгөөн 6 хүн байна. Байгууллагын багш ажилтны цалин хөлс шагнал урамшуулалд зарцуулсан нийт зардал</p> | 100 |


| | | | | | |
|----|----|---|--|----|--|
| 26 | | | <p>67% байна Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт багш ажилтан 100%, Улаан бурхан өвчний дархлаажуулалтад 98% хамрагдсан. Багш ажилтны ажиллах таатай нөхцөл боломжоор хангах зорилгоор бүлгийн 3 багш, Нягтлан бодогчийн зөөврийн компьютерээр хангасан. Нийт багш нар 100% компьютерээр хангагдсан байна Ахмадын баяраар манай байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан 10 ахмад настныг хүлээн авч хүндэтгэл үзүүлээд байна.</p> | | |
| 28 | 28 | <p>“Илүүдэл жингүй” эртэч Монгол аян зохион байгуулах тухай 2022.02.16 А/69</p> | <p>Монгол улсын Ерөнхий сайдын санаачлагаар зохион байгуулагдсан "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" энэхүү аяны хүрээнд Ахмадын хорооноос ахмадууд нэгдэн “Эрүүл байхын үндэс, Эрүүл агаар хөдөлгөөн,” нэртэй аян 2024 оны 04 дүгээр сарын 01-с эхлэн өрнүүлсэн. Уг арга хэмжээ өргөжин албан байгууллагын алба хаагчид, Аж ахуй нэгж, ард иргэд, залуучууд нэгдэн боломжтой цаг хугацаандаа өглөө эртлэн босож сумын төвөөс баруун тийш ирж буцах 2-3 км газар алхалт, гүйлт хийж очсон газраа 20-25 минут идэвхтэй дасгал хөдөлгөөн, Бясалгал, Залбирал хийн хуваарийн дагуу үйл ажиллагаа зохион байгуулан оролцдог. Эрүүл мэндийн байдал, насны онцлогоос шалтгаалан тэгш хэмтэй газар, уул, өндөрлөг газар явах алхалтын зай янз бүр байдаг. Тус аянд өглөөдөө 30-40 хүн оролцон эрүүл агаарт нийтийн биеийн тамирын идэвхитэй дасгал хөдөлгөөн хийн өөрсдийгөө эрүүлжүүлэн чийрэгжүүлж эрүүл мэнддээ үнэтэй хувь нэмэр оруулж байна. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Эмэгтэйчүүдийн зөвлөл, Эмэгтэй төлөөлөгчид, Ахмадын хороо, Соёлын төв хамтран 2024 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 10 цагт сумын Ерөнхий боловсролын сургуулийн спорт зааланд бүх эмэгтэйчүүдийн дунд нас харгалзахгүй сугалаагаар баг бүрдүүлж Волейболын тэмцээн, Дартсны тэмцээн (зөвхөн 45-аас дээш насны) эмэгтэйчүүдийн дунд, мөн орой нь Азын сугалаатай цэнгээнт бүжиг 19 цагаас соёлын төвд нийт бүсгүйчүүдийн хүрээнд арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Уг арга хэмжээнд Волейболлын төрөлд 8 багийн 64 тамирчид, Дартсын төрөлд 35 тамирчид оролцон давхардсан тоогоор 112 эмэгтэйчүүд тус үйл ажиллагаанд хамрагдсан байна. Сургуулийн өмнөх насны хүүхдийн цээж, гэдэс, нуруу, хөлийн булчинг хөгжүүлэх дасгал, үндсэн хөдөлгөөнүүд, тэнцвэрийг сайжруулах дасгалыг “хөдөлгөөн-эрүүл мэнд” цагаар өдөр бүр 2-5 насны хүүхдүүдийн дунд бие бялдрын онцлог, насны ангилалаас нь хамааран тоглоомон хэлбэрээр, дууриан хийх аргаар өглөөний дасгал 08:00-08:30 минутын хооронд бие бялдрын хөгжилийг сайжруулах зорилгоор</p> | 90 | |

цэвэр агаартай өрөөнд хийлгэж хэвшсэн байна. Нэг хөдөлгөөнийг 5-6 удаа давтан хөгжилтэй, хөгжөөнтэй, инээдтэй арга барилаар дасгал хөдөлгөөн хүүхдүүд хийдэг. Цаг агаар сайхан тогтуун үед аль болох гадаа агаар салхинд бөмбөгөөр тоглох, цагираг эргүүлэх, гулсуур дээр гулгах, нуугдаж тоглох зэрэг хүүхдийн идэвхтэй хөдөлгөөнийг дэмжин ажилладаг. **“Автомашингүй-Тамхигүй өдөр”**-ийн хүрээнд 05 дугаар сарын 31-ний өдөр Ажлын хэсэгээс зохион байгуулсан “Марафон-2024” гүйлтэд төрийн албан хаагч 47, Иргэн 3, хүүхэд 1 хүн оролцон Иргэдийн төлөөлөгчийн хурал, Засаг даргын Тамгын газар нь багаараа түрүүлэн амжилттай оролцлоо. 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр 6-12 дугаар ангийн сурагчдын уншиж ойлгох чадварт сургах, бие даан сурах арга барил эзэмшүүлэх, чөлөөт цагаа ангиараа хамтарч ажиллах, үр бүтээлтэй өнгөрүүлэх боломжийг нэмэгдүүлэх, бие бялдрын зөв хөгжил олоход дэмжлэг үзүүлэх зорилгоор “Олимп” явган аялал, үйл ажиллагааг удирдамжийн дагуу амжилттай зохион байгууллаа. Аяллын хүрээнд монгол хэл – уран зохиол /түлхүүр үгийг ашиглан шүлэг зохиох, хэлц үгийн утгыг тайлбарлаж өгүүлбэрт хэрэглэх, түүх /олимп болсон хот, улсуудын байршил ба хүн ам, түүх/, газарзүй /олимп болсон хот, улсуудын бэлгэдэл/, биеийн тамир хөгжил, олимпын 5 цагариг, эв нэгдлийн бэлгэдэл/, биеийн тамир /олимпын наадамд оролцож амжилт гаргасан монгол тамирчид, олимпын наадмын төрөл/, англи хэл /олимпын наадмын бэлгэдэл/, хөгжим - /гэрийн даалгавар/ гэсэн хичээллүүдийн хүрээнд өртөөчилсэн асуулт даалгавар гүйцэтгэхийн сацуу орс таталт, талын зээр, уулын оргил булаалдах, багийн хөгжөөнт тэмцээн, үндэсний бөхийн барилдаан зэргийг зохион байгууллаа. 2024 оны 05 дугаар сарын 31-ны өдөр Иргэдийн төлөөлөгчийн хурал, Ерөнхий боловсролын сургууль хамтран удирдамж боловсруулан 1-3 дугаар анги, 4-6 дугаар анги, 7-9 дүгээр анги, 10-12 дугаар ангийн нийт 78 сурагчдийн дунд сургуулийн аварга шалгаруулах Үндэсний бөхийн барилдаан зохион байгуулсан. Монгол үндэсний өв соёл, уламжлалаа хүүхэд багачуудад сурталчилах үндэсний бөхөөр хичээллэж буй сурагчдын тоог нэмэгдүүлэх, өсвөр үеийн хүүхдийн барилдааны ур чадварыг сайжруулахыг зорилго болгон ажиллалаа. 2024 оны 04 дүгээр сарын 20-с 05 дүгээр сарын 08-ны хооронд Есөнзүйл сумын Төсөвт 5 байгууллагын алба хаагчид, аж ахуй нэгж, ард иргэдээс “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгшилтийн түвшин тогтоох”-ыг хурд, гарын хүч, хөлийн хүч, хэвлийн хүч, тэсвэр, тэнцвэр, уян хатан гэсэн 7 төрлөөр сорил авах аяныг зохион байгуулах ажлын хэсгийг 8 хүний бүрэлдэхүүнтэй байхаар Засаг даргын захирамж гарган ажилласан.

| | | | | |
|----|----|---|--|-------|
| 27 | 29 | Малын халдварт, шимэгчтгэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай 2023.03.04 №А/95 | Тус сумын мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх өвчний вакцинжуулалтын 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу "Чин дөрвөн мэнд" хувийн мал эмнэлгийн малын их эмч В.Сугаррагчаа 2024 оны 04 сарын 10 өдрийн А/46 дугаар захирамжаар мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд ДХХ-14500 бог, ДХХ Энтробактериоз -10950 бог, цусан халдварт 750 бод, Дуут хавдар 380 бод малд тус тус урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1,2,3,4 -р багийн төлөвлөсөн айл өрхийг бүрэн хамруулан ажиллаад байна. | 90 |
| 28 | 30 | Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр оруулан хаалгах болон төлбөрөөс чөлөөлөр тухай 2023.05.31 №А/283 | Тус сумаас цэргийн дүйцүүлэх албанд 2024 оны 3 дугаар улирлын байдлаар цэргийн дүйцүүлэх албыг хааж буй иргэн байхгүй байна. 2024 оны 10 дугаар сарын байдлаар 2 иргэн мөнгөн төлбөрийн тооцоог хийн ажиллаж байна. | 90 |
| 29 | 31 | Мал амьтаны гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай 2024.08.02 №А/597 | Тус суманд мал амьтны гоц халдварт "хонины цэцэг" өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу "Чин дөрвөн мэнд" хувийн мал эмнэлгийн малын эмч В.Сугаррагчаа 2024 оны 06 сарын 03-ны өдрийн А/03 дугаар захирамжаар гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1,2,3,4 -р багийн бог 28000 толгой мал төлөвлөснийг 27730 толгой хонь буюу 99 хувийн гүйцэтгэлтэй хийгдээд байна. | 100 |
| 30 | 32 | Бруцеллёзын вакцинжуулалтын ажлыг зохион байгуулах тухай 2024.03.13 №А/193 | Тус сумын мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бруцеллёз өвчний вакцинжуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу "Чин дөрвөн мэнд" хувийн мал эмнэлгийн малын эмч В.Сугаррагчаа 2023 оны 08 сарын 14 өдрийн А/104 дугаар захирамжаар бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1,2,3,4 -р багийн тугал 650, хурга 17200, ишиг 9800 нийт толгой малд тун вакциныг 99% хувийн гүйцэтгэлтэй хийгдээд байна. | 100 |
| | | | Бүлгийн дундаж дүн | 97,1% |
| | | | ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ | 92,6% |

ХЯНАСАН: СУМЫН ЗАСАГ ДАРГА Т.БАТ-ӨЛЗИЙ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН



T. МӨНХЗУЛ